

ТАНИЛЦУУЛГА

Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Нэг. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн үзэл баримтлал нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Улсын Их хурлаас 1993 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг батлан гаргажээ.

Эрх зүйн тогтолцооны шинэчлэл, нийгмийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор 2002 онд Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн баталж мөрдүүлсэн нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд энэ хугацаанд 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр, Шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл, нийгмийн харилцааны хувьсал, өөрчлөлт, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг гол хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан одоо мөрдөгдөж байгаа Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэх, үзэл баримтлал, зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарсан.

Прокурорын байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн зөвлөмж хэсэгт зөрчил, гэмт хэргийг шалгах, хянах, шийдвэрлэх ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагаа зэргийг зохицуулсан хуулиудын төсөлтэй нийцүүлэн Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг дурьдсан байна.

Иймд дээр дурьдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан зарим нэр томъёог оновчтой болгох, Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эрүүгийн хууль тогтоомжийн төслүүдтэй уялдуулах, прокурорын байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, прокурор үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэргийг тодорхой зохицуулсан Прокурорын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгох зарчмууд нь хүний эрх, эрх чөлөөг хангахад суурилсан, хэрэгжихүйц байхаар, байгууллагын тогтолцоог хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах боломжтой байхаар, түүнчлэн прокурорын зэрэг дэвийг албан тушаал, ажилласан жил, ур чадвараас хамаардаг байхаар

шинээр тусгаж, туслах прокурор, туслах ажилтан, дүүргийн прокурор зэрэг зарим ойлгомжгүй нэр томъёог шинээр тусгахдаа туслах прокурор зөвхөн Улсын ерөнхий прокурорын газарт байхаар зохицууллаа.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр боловсруулагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл зэргийн үзэл баримтлал, зохицуулалттай уялдуулан прокурорын чиг үүргээ хэрэгжүүлэхэд эдлэх бүрэн эрх, эрх хэмжээг тодорхойлов. Түүнчлэн прокурор төр, нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилгоор талуудын хүсэлтээр эсвэл өөрийн санаачлагаар захиргааны болон иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчийг төлөөлөн оролцох чиг үүргийг шинээр тусгаж, уг чиг үүргийн хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт сэлт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулах бүрэн эрхтэй байхаар тусгалаа. Прокурор шинээр “нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах” чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой “нэхэмжлэл, гомдол” гаргахаар томъёолсон.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу прокурор шүүх эрх мэдэлд багтдаг тул Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуультай ижил агуулгаар прокурор нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, хараат бус байдалд нь халдсан аливаа дарамт, шахалт, нөлөөллийн талаар дээд шатны прокурорт мэдүүлэх үүрэгтэй байхаар шинээр заалт оруулсан.

Хуулийн төсөлд тусгагдсан дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн Хууль, Нэгдсэн Үндэстний байгууллагын гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар, Олон улсын прокуроруудын холбооноос гаргасан “Прокурорын үндсэн эрх, үүргийн тунхаг болон мэргэжлийн хариуцлагын стандарт”-ын үзэл санаа, түүнд орсон зохицуулалтууд, олон улсын хэмжээнд прокурорын үйл ажиллагаанд мөрдлөг болгодог хэм хэмжээнүүд, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг хууль тогтоомжуудад үндэслэгдсэн болно.

Прокурор ажиллах хугацаандаа болон өндөр насны тэтгэврээ тогтоолгох, эмчлүүлэх, ажил үүргээ гүйцэтгэж явахдаа тахир дутуу болсон, бэртэж гэмтсэн тохиолдолд авах нөхөн төлбөр, буцалтгүй тусламжийн хэмжээг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуультай уялдуулан тодорхойлов.

Түүнчлэн нийгмийн баталгаанд дан ганц прокурор бус, ажил үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдсан прокурорын гэр бүлд буцалтгүй тусламж үзүүлэхээр тусгасан. Ингэснээр прокурорын байгууллагын ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллах, алба үүргээ шударгаар биелүүлэх, аливаа гадны хууль бус нөлөөллөөс прокурорыг хамгаалах нөхцөл бүрдэх юм.

Хоёр. Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдон шинээр боловсруулсан хуулийн төслийн талаар:

1.Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсантай холбогдуулан Прокурорын байгууллагын тухай хуулийг хүчингүй болгох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсрууллаа.

---oOo---